



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/465

Улаанбаатар хот

Дүүргийн 9 дүгээр хорооны Шархадны эмнэлгийн гудамжны гэрэлтүүлгийн ажлын барьцаа хөрөнгө чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2016 онд Дүүргийн 9 дүгээр хорооны Шархадны эмнэлгийн гудамжны гэрэлтүүлгийн ажлыг гүйцэтгэсэн "И Пи Эс групп" ХХК-ний барьцаа 3 739 576 /гурван сая долоон зуун гучин есөн мянга таван зуун далан зургаан/ төгрөгийг барьцаа хөрөнгийн данснаас чөлөөлөхийг Засаг даргын Тамгын газар /Б.Амартүвшин/-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн хөгжлийн асуудал хариуцсан төслийн удирдагч-Засаг даргын орлогч Д.Уламбаярт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ